



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 321

Улаанбаатар хот

“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 670 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн зарим үзүүлэлтийг 1 дүгээр хавсралтад заасны дагуу өөрчилсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 670 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний 1-т “Ус хийгүйжүүлэх төхөөрөмж (төмрийн үртсэн деаэратор) суурилуулах 22.00 сая төгрөг” гэснийг “Ус хийгүйжүүлэх төхөөрөмж (төмрийн үртсэн деаэратор) суурилуулах 42.00 сая төгрөг” гэж өөрчилсүгэй.

3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 670 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээг нэмсүгэй.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002121


**“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшин**

Төрийн өмчийн боллого, зохицуулалтын газрын
2018 оны 07 дугаар сарын 25 ны өдрийн
321 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



Д/д	Эдийн засгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он				Харьцуулалт	
				Анхны төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Толотгосон төлөвлөгөө	2018 оны тод-2018 төлөв	2018 тод/2018 төл	
2	Нийт орлого	мян.төг	2 063 275,6	2 438 096,4	2 619 596,3	2 619 596,3	181 500,0	107,4	
	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	1 998 072,8	2 385 007,6	2 465 007,6	2 465 007,6	80 000,0	103,4	
3	Нийт зардал	мян.төг	2 601 422,7	3 106 121,0	3 281 424,4	3 281 424,4	175 303,4	105,6	
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(538 147,1)	(668 024,6)	(661 828,1)	(661 828,1)	6 196,5	99,1	
6	Цэвэр ашиг/алдагдал	мян.төг	(83 601,7)	(168 024,6)	(161 828,1)	(161 828,1)	6 196,5	96,3	
7	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	12 746,8	13 120,8	29 284,2	29 284,2	16 163,4	223,2	
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг-ДЭХ	төг	65 403,0	75 235,9	79 482,0	79 482,0	4 246,2	105,6	
12	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1,26	1,27	1,25	1,25	(0,02)	98,3	
14	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	мян.төг	171 501,6	183 705,5	383 705,5	383 705,5	200 000,0	208,9	
16	Нийт өглөг	мян.төг	1 346 682,0	742 554,0	812 629,2	812 629,2	70 075,2	109,4	

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 07 дугаар сарын 03 ны өдрийн
321 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ,
хөрөнгө оруулалтын төлөвлөгөө**

Д/д	Хийгдэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Нийт дүн /сая төг/
Гурав. Хөрөнгө оруулалт					
6	Автобус	ширхэг	1		47,00
7	Суудлын автомашин	ширхэг	1		133,00
	Дүн				180,00
	Нийт дүн				180,00